

# “Монгол эдийн засагчдын чансаа” өгүүллийн талаар эргэцүүлэл

Нинжбатын Ууганбаатар\*

Монгол Улсын их сургууль, Улаанбаатар, Монгол Улс

Др. Б.Эрдэнэбатын өгүүлэл нь монгол эдийн засагчид судалгааны хувьд ямар түвшинд байна вэ? гэсэн асуултад тодорхой хариулт өгөхийг зорьжээ. Ингэхийн тулд:

1. Монгол эдийн засагчдын талаар болон эдийн засгийн сургалт явуулдаг ИДС-ийн талаар мэдээлэл цуглуулах,
2. Бусад судлаачдын хийсэн ижил төстэй ажлуудтай танилцах,
3. Чансаа тогтоох боломжит хувилбаруудаас тохиромжтойг нь сонгох,
4. Сонгосон аргачлалаараа цуглуулсан өгөгдлөө шинжлэх,
5. Гарсан үр дүндээ үндэслэн тодорхой зөвлөмж гаргаж, санал дүгнэлт боловсруулах,
6. Хийсэн судалгаагаа эрдэм шинжилгээний өгүүлэл хэлбэрээр тайлагнах

гэсэн үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Уншигчийн зүгээс харвал эдгээр үндсэн ажлуудаас (1), (2), (4), (6)-ийг өндөр түвшинд гүйцэтгэсэн санагдав. Харин (3) дахь ажлын хувьд өгүүлэлд илүү тодорхой оруулсан бол зүгээр байж гэсэн бодол төрөв. Тухайлбал эрэмбэ, чансаа тогтооход ашиглаж буй гол томъёо нь ямар шинж чанаруудтай болох талаар огт дурдсангүй нь харамсалтай.

(5) дахь ажлын тухайд сонирхолтой дүгнэлтүүд олон байгаагийн дунд манайд одоогийн мөрдөгдөж буй цол, зэрэг, албан тушаал олгох хэлбэр нь олон улсын жишиг болон стандартаас хол зөрсөн байгааг тод томруунаар харуулжээ. Эндээс

- Нөхцөл байдал чухам яагаад ийм байна?
- Одоогийн энэ тогтолцооны сайн (хэрэв байгаа бол) болон саар талууд юу вэ?

---

\*Математикийн тэнхим, МУИС. email: uugnaa.ninjabat@gmail.com

гэсэн сонирхолтой асуултууд урган гарах бөгөөд цааш дэлгэрүүлэн авч үзвэл зохилтой. Зохиогчийн санал болгож буй бодлогын шинжтэй

- Одоогийн байгаа хүчин чадалдаа тулгуурлан ‘center of excellence’ байгуулах,
- Гадаадад байгаа идэвхтэй судалгаа явуулж буй эрдэмтдэд хандсан зарим арга хэмжээнүүд авах

гэх мэт зөвлөгөөнүүд анхаарал татаж байна. Тэднийг дотор нь засгийн газрын түвшинд, нэгж байгууллагын түвшинд, хувь хүний түвшинд хэмээн ангилах, мөн хоорондын уялдаа холбоог авч үзэх, боловсруулах санал тус бүрийн үр нөлөөг тодруулж, таамаглах зэргээр цаашид сайжруулж болохоор харагдаж байна.

Энэ ажлыг ерөнхийд нь харахад хэд хэдэн өөр шинжүүр ашиглан эрэмбэлж болох аливаа объектуудын эрэмбүүдийг нэгтгэн сайн шинж чанартайгаар эрэмбэлэх нь онолын хувьд боломжгүй байх тухай Арроугийн боломжгүйн теорем санаанд буув. Үүнээс гадна

- Чансаа (rating) болон эрэмбэ (ranking) гэсэн ойлголтууд нэг ижил үү?
- Сэтгүүлийн эрэмбэ дээр тулгуурлан судлаачдыг эрэмбэлэх, судлаачдын эрэмбэ дээр тулгуурлан байгууллагуудыг эрэмбэлэх нь аргачлалын хувьд зөв зүйтэй юу?
- Өөрөөр хэлбэл нэг эрэмбэ ашиглан нөгөөг эрэмбэлэх нь онолын хувьд үндэслэлтэй юу? эхний шатны эрэмбэ дээрх ямарваа алдаа (bias) нь дараагийн шатанд улам их хэмжээнд сөргөөр нөлөөлөх боломжтой юу? гэсэн сонирхолтой асуулттай таарав.

Сэтгүүлийг эрэмбэлдэг имфакт фактор нь зарим дутагдалтай байдаг нь нэгэнт ил болсон. Тухайлбал

- Өөрийгөө ишлэх явдлыг тооцдоггүй,
- Салбар хоорондын зөрүү их байдаг,
- Жинхэнэ судалгааны ажлаас илүү судалгааны тойм (review) ажилд илүү ач холбогдол өгдөг,
- Англи хэл дээрх сэтгүүлүүд илүү байр суурьтай байдаг гэх мэт.

Ер нь орчин цагийн эдийн засгийн судалгаанд АНУ, ИБУИНВА нь томоохон байр суурь эзэлдэг нь үнэн хэдий ч, 19-р зуун болон 20-р зууны эхний хагаст нөхцөл байдал өөр байсныг санах хэрэгтэй. Тухайлбал Герман, Франц, Голланд, Австри, Швед зэрэг улсууд бүгд өөр өөрийн уламжлалтай, дэг сургуультай байсан бөгөөд глобалчлалын эрч саарч буй энэ мөчид эдийн засгийн ухаанд ч гэсэн олон төвт систем иргэн ирэхийг үгүйсгэхгүй.

Эцэст нь эдийн засгийн чиглэлд судалгаа хийдэг болон салбарын бодлого боловсруулахад оролцдог бүх хүнийг энэ судалгааны ажилтай нухацтай танилцахыг санал болгоод зохиогчийн цаашдын ажилд амжилт хүсье!